

Рибекa Трэйс

Дэлхийн
хүүхдүүдийн тухай
Оксфордын анхны
НОМ



Рибекa Трэйс

*Дэлхийн
хүүхдүүдийн тухай*

Оксфордын анхны
НОМ



Улаанбаатар хот 2007 он

Рибекa Трэйс

**Дэлхийн хүүхдүүдийн тухай
Оксфордын анхны ном**

Швед хэлнээс орчуулсан Н.Оюунбаяр
Хянасан Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Н.Хадвалмор



Хэвлэн нийтлэхийг Интерпресс ХХК
2007 он



Гарчиг



| | |
|---------------------------------------|----|
| Бидний гэр бүл | 6 |
| Бидний гэр орон | 8 |
| Суурин газар ба хөдөө нутаг | 10 |
| Кристин ба Марио | 12 |
| Хотууд | 14 |
| Тэйлор Бади хоёр | 16 |
| Газар тариалан, мал аж ахуй эрхлэх нь | 18 |
| Хью, Аданна, Данейл нар | 20 |
| Эд зүйлс хийх | 22 |
| Дэлгүүрээр явж худалдаа хийх | 24 |
| Дуртай хоол хүнс | 26 |
| Бусдын төлөө ажиллах | 28 |
| Хүүхүүд сургууль дээр | 30 |
| Хүүхдүүд тоглож байна | 32 |
| Бидний итгэдэг зүйл | 34 |
| Хамтдаа тэмдэглэцгээе | 38 |
| Бидний ирээдүй | 40 |
| Баримт мэдээлэл | 42 |
| Индекс | 44 |



Танилцуулга

Энэ номноос чи дэлхийн янз бүрийн орны хүүхдүүдтэй танилцах болно. Тэдний гэр бүл, гэр, сургууль, юунд дуртай, дургүйг мэдэх болно. Өөр бусад оронд амьдрал ямар байдаг, хүүхдүүдийн амьдралд ямар ялгаа, ямар ижил төстэй зүйлүүд байдгийг олж мэдэх болно.



^ Намайг Марио гэдэг. Би Гватемалад амьдардаг. Миний амьдардаг жижиг хот уулын хөндийд байдаг.

> Миний нэрийг Мария гэдэг. Би Бразилын Рио Де Жанейро гэдэг том хотод амьдардаг. Тэрээр далайн эрэг дээр орших бөгөөд Кококабана гэдэг гайхамшигтай сайхан наран шарлагын газартай.



> Намайг Кристин гэдэг. Би Норвегийн загас агнуур хөгжсөн тосгонд амьдардаг. Энд ямагт цастай байдаг. Би бараг халд орохоосоо өмнө гулгаж сурсан.



< Намайг Рави гэдэг. Би Энэтхэгийн хамгийн том хот болох Калькутад амьдардаг. Энд Мейли гэдэг асар том парк бий. Тэнд би крикет тоглодог.

Бидний гэр бүл

Дэлхийн хаана ч хүүхдүүд өөр өөрсдийн гэр бүлийн хамт амьдардаг. Харин гэр бүл олон янз байдаг. Зарим хүүхдүүд зөвхөн эцэг эхийнхээ нэгэнтэй нь л амьдардаг. Өөр нэг хэсэг нь эцэг эх, ах эгч, өвөө эмээ, авга нагац болон үеэлүүдийнхээ хамт амьдардаг. Том ч бай, жижиг ч бай гэр бүлүүд бие биедээ тусалдаг. Тэд гэрийнхээ ажлыг хамтран хийж, мөнгө, хоол хүнсээ хуваалцдаг. Ингэж бие биенээ асарч халамжилдаг.



Аяс

Миний нэрийг Аяс гэдэг. Би ээж аав, гурван дүү, авга нагац нар, найман үеэл, мөн эмээгийнхээ хамт Турк улсад амьдардаг. Манай ам бүл нийлээд арван наймуулаа. Бид их хөгжилтэй амьдардаг. Яагаад гэвэл надад хэн нэгэн тоглох хүн дэргэд минь дандаа байдаг. Миний ээж аав хоёр ажилдаа явчихдаг. Иймээс намайг болон миний дүү нарыг авга эгч нар маань хардаг.

< Энэ зургийг миний эмээгийн жаран насны ойн өдөр авсан юм. Би цэцгэн хээтэй юбка өмсч, хамгийн урд талын эгнээнд, доор сууж байна.

Вики

Намайг Вики гэдэг. Би ээж, аав, ахынхаа хамт Канадад амьдардаг. Би найман настай, миний ах арван настай. Тэрээр ихэвчлэн надтай сайхан харьцдаг боловч, түүний компьютерийн тоглоомыг нь авахад тэр дургүй байдаг. Надад үеэлүүд бий. Гэхдээ тэд биднээс хол амьдардаг. Бид тэдэнтэй жилд нэг удаа Америкчуудын гэр бүлийн баяр болох Талархлын баярын өдрөөр эмээгийнхээ гэрт уулздаг.

Дасгал ажил

Хэрэггүй ном, багахан цавуу ашиглан өөрийнхөө гэр бүлийнхний зургийн цомгийг хийгээрэй. Аль болох олон хамаатнуудынхаа зургийг оруулахыг хичээгээрэй. Гэр бүлийнхээ ахмад хүнээс тусламж хүс. Тэдэнд чиний урьд өмнө нь сонсож байгаагүй холын хамаатнуудын чинь зураг ч байж болох юм.



< Бидний гэр модон тулгуур дээр баригдсан байдаг ба гуалин болон хулсаар хийсэн байдаг. Би шатны дээр аав, дүү хоёрынхоо хамт сууж байна.

Руди

Намайг Руди гэдэг. Би аав, ээж, дүүгийнхээ хамт Борнео арал дээр амьдардаг. Бидний амьдардаг модон тулгуур дээр барьсан урт модон байшинд өөр бас гуч гаруй айл байдаг. Айл гэр бүрийн сууц нь хооллодог, унтдаг тусгай тасалгаатай. Энд заримдаа жаахан чимээ шуугиантай боловч надтай хол бөмбөг тоглох хүүхэд олдохгүй байна гэж байдаггүй.


Бидний гэр орон

Амьдардаг байшин маань бидний гэр орон юм. Энэ нь гэр бүл хамтдаа идэж, амарч, унтаж, тоглож байдаг газар юм. Дэлхийн эргэн тойронд бүхий л төрлийн өөр өөр гэр орон байдаг. Зарим хүмүүс өндөр дөрвөлжин блокон байшинд амьдардаг бол зарим нь жижиг сууц буюу урцанд амьдарна. Бидний суудаг гэр орон амьдардаг улс орны маань цаг агаарт тохирсон байдаг.



^ Энэхүү өмнөд Америкийн сууцны шавраар хийсэн байдаг. Харин үүнийгээ хээ угалзаар гоёдог байна. Энд зургаан гиншүүнтэй гэр бүл амьдардаг.

> Энэтхэгийн Бомбей хотод байдаг энэхүү аварга том хавтгай блокон байшинд олон гэр бүл амьдардаг. Орой дээрээс нь чин хотын дээгүүр хэдэн километр газрыг харж чадна. Хана, шалууд нь төмөр баганаар хийгдсэн байх ба ган тулгуур хүрзэн дээр тогтдог.



Ойртоод хар

Зарим хүмүүс хөвдөг сууцтай байдаг. Эдгээр завин сууцууд нь Лондон хотын Темза гол дээр байдаг. Завин сууцанд цэцэрлэг байдаггүй учир хүмүүс заримдаа дээвэр дээрээ савтай цэцэг тавьдаг. Завин сууцан дээр чин хөршүүдтэйгээ найрсаг байх хэрэгтэй. Яагаад гэвэл гэрийнхээ хаалга уруу очихын тулд тэдний завин дээгүүр дамжиж гарах хэрэг гардаг.





< Энэхүү чулуун сууц нь Шотландын Эдинбург хотод байдаг. Энэ нь нэг л айлын сууц байсан боловч одоо гурван айл амьдарч байна.



> Энэ Оросын сууцныг ойролцоох ойгоос бэлтгэсэн гуалингаар хийжээ. Өвөл нь энэ гэр бүл гал тогооныхоо өрөөний том зуухны орчимд ихэнх цагаа өнгөрүүлдэг.

Оюун

Намайг Оюун гэдэг. Би Монгол улсад амьдардаг. Миний амьдардаг сууц том, дугуй хэлбэртэй бөгөөд «гэр» гэж нэрлэдэг. Тэрээр модон хана, эсгий болоод брезингэн бүрээстэй байна. Манай гэрийн дотор дулаахан бөгөөд өнгөлөг. Будсан тавилгаар дүүрэн бөгөөд хурц өнгөтэй дэвсгэр дэвссэн байдаг. Гэр бол бидний унтаж, идэж, тоглож, мөн гэрийн даалгавраа хийдэг нэгхэн том өрөө юм. Хэрвээ миний дүү намайг зовоогоод байвал би морио унахаар гараад явчихдаг.



^ Гэрийг нүүдлэхэд хялбар байдаг. Энэ зурган дээр нэгэн айл гэрээ барьж байна.

> Би ээж дүүгийнхээ хамт цай ууж байна.



Суурин газар ба хөдөө нутаг

Бидний гэр орон ихэнхдээ тосгон, суурин газар эсвэл хотуудад харьяалагддаг. Хөдөө амьдарч буй хүүхдүүд тоглох ой мод, талбайтай байдаг. Суурин ба хотуудад амьдардаг хүүхдүүд гудамжинд, эсвэл паркт тоглодог. Тосгонд тийм ч олон дэлгүүр байдаггүй. Иймээс хүмүүс эд юм худалдан авахын тулд суурин уруу явдаг. Томоохон суурин газар ба хотын хүмүүс хэрэгцээтэй зүйлийнхээ ихэнхийг дэргэдээ байлгадаг.



Мосисийн тосгон

Мосис өмнөд Америкийн нэгэн тосгонд амьдардаг. Тэнд дэлгүүр байдаггүй бөгөөд түүнд ойр орших суурингаас хол зайтай байдаг. Тосгоныхон хэрэгцээтэй эд зүйлсээ ургуулж, эсвэл өөрсдөө хийдэг. Мосисийн ээж нь сав суулга, хувцас оёх даавуу хийдэг. Түүний аав нь суушаа барьсан бөгөөд түүнийгээ арчилдаг. Тосгоны суушнууд нь «краал» гэж нэрлэдэг дугуй сууц юм. Шөнөдөө тосгоныхон малаа аюулгүй байлгах үүднээс гэртээ оруулдаг.

Инесийн тосгон

Инес нь Испани улсын нэгэн тосгонд амьдардаг. Тэндхийн хамгийн том барилга нь баруун гар талд төвд байгаа сүм юм. Сүмийн гаднах талбай нь цугларалтын газар юм. Инес хичээлийнхээ дараа энд тоглодог. Тосгонд эмч, талхчин, жижигхэн дэлгүүр, кафе байдаг боловч сургууль байдаггүй. Инес өдөр бүр автобусаар ойролцоох суурингийн сургууль уруу явдаг.

> Тосгоны талбай. Зун хүн бүр энд үдэшлэгт ирдэг.



< Зарим тосгон томорч суурин болдог. Далай орчмын суурингууд ямагт наран шарлагын газар болон завчны сайн зөгөөд бүхий газруудаараа өргөжин томордог. Энэ бол Англи улсын далайн эргийн хот юм. Зуны улиралд олон тооны жуулчид ирдэг бөгөөд халуун өдрүүдэл наран шарлагын газарт хүн үнэхээр ихтэй байдаг. Өвөл нь олон дэлгүүр кафе ресторонууд хаагддаг ба хот хоосорсон мэт санагддаг.

Кристин ба Марио



Энэ бол манай тосгон.

Кристин

Намайг Кристин гэдэг. Би Норвегийн уулын тосгонд амьдардаг. Уулс маш сайхан харагддаг бөгөөд бүхэлдээ цасаар хучигдсан байдаг. Манай тосгон маш жижигхэн. Заримдаа би илүү олон дэлгүүр, кино театрууд байгаасай гэж хүсдэг. Миний аав ээж, хэдэн жилийн өмнө энд олон гэр бүл нүүж ирсэн боловч тэдний ихэнх нь хот суурин уруу нүүчихсэн гэдэг. Өвөл би өдөр бүр гулгадаг.

Дасгал ажил

Өөрийнхөө оронд нүүж ирж байгаа хүүхдэд зориулсан дүүрэн мэдээлэл бүхий бичхэн ном хий. Бусад хүүхдүүд мэдэхийг хүссэн зүйлсийн талаар бодохыг хичээ. Тоглож болох хамгийн сайн газар нь хаана байх вэ? Хамгийн сайн чихрийн дэлгүүр эсвэл авирах мод аль нь вэ? Чи тэр номондоо зурсан зураг, фото зураг болон план зураг оруул.






Марио

Намайг Марио гэдэг. Би Гватемалад уулын сууринд амьдардаг. Ихэнх өдрүүдэд чимээ шуугиангүй боловч зах гардаг өдрүүдэд хүн, хөл хөдөлгөөн ихтэй болчихдог. Хүмүүс жимс ногоо, хувцас, сав суулга зэрэг бүхий л төрлийн зүйлүүдийг борлуулах тавцангаа байрлуулдаг. Би тэдний зарлаганд гүйж мөнгө олдог.



> Би өөрийнхөө хамгийн дуртай гутлыг өмсчөөд байгаа нь.



^ Хотын олон хэсгүүдэд хэзээ ч харанхуй болдоггүй ээ. Яагаад гэвэл тэр гудамжууд олон өнгийн гэрлээр шаарч байдаг билээ.

v Энэ бол Японы нэгэн том хотын шөнийн байдал.

Хотууд

Том хотууд бол дэлхийн хамгийн сэтгэл хөдөлгөм газруудын нэгээхэн хэсэг нь юм. Тэнд сая сая хүмүүс хамтдаа амьдарч, ажиллаж, тоглодог. Өнөөдөр хүмүүс олноороо хөдөө орон нутгаас хот уруу нүүн орж ирж байна.

Шөнийн цагаар

Хотууд хэзээ ч унтдаггүй гэлтэй. Шөнө хүмүүсийн хөгжил цэнгэлээр амьдрал үргэлжилсээр байдаг. Кино театрууд, урлагийн газрууд, шөнийн клубууд, баар рестораниуд бүгд л орой болтол нээлттэй байдаг. Зарим гудамжууд нь өдрийн цагаасаа ч илүү шөнө нь хүнээр дүүрэн байдаг.





Өдрийн цагаар


Өдрийн цагт хотуудад мөн л ажил ундарч байдаг. Мянга мянган ажилчид, худалдан авагчид, жуулчид гудамжаар дүүрэн байдаг. Хүмүүс ресторан, кафед идэж ууж, хүүхдүүд паркад тоглож байдаг. Ийм олон хүнийг нэг газарт байлгах нь байнга асуудал үүсгэж байдаг. Машин тэрэг олноор байдаг гудамжинд бөглөрөл үүснэ. Энэхүү замын хөдөлгөөнөөс гарч байдаг утаа угаар нь агаарыг бохирдуулж хүмүүсийг ч өвчлүүлж байна. Зарим хотууд замын хөдөлгөөнийг хориглосон гудамжуудтай байх нь бий.

< Стокхольм хотын энэ гудамжинд зөвхөн хүмүүс л зорчдог. Ингэснээр тухайн газрын аюулыг багасгаж, ачааллыг нь бууруулж, элдвийн үнэр үнэртэхээс хамгаалдаг.



Ойртоод хар

Итали улсын нийслэл Рим зэрэг хотуудад урт удаан хугацааны түүхтэй орчин үеийн оффисын барилгууд, дэлгүүр, хоршоо, авто замын хажууд эртний барилгууд байдаг. Тэдгээрийн зарим нь мянгаас ч илүү жилийн настай байдаг.



^ Энэхүү барилга нь Рим дахь Колизей. Эртний Римчүүд үүнийг ойролцоогоор хоёр мянган жилийн турш барьжээ. Тэд Гладнаторуудын тулааныг үзэхэд зориулагджээ.

Тэйлор, Бади хоёр

Тэйлор

Миний нэрийг Тэйлор гэдэг. Би Америкийн Санфранциско хотод амьдардаг. Манай байшин хотын захад байдаг. Миний ээж аав хоёр хот уруу ажилдаа машинаар явдаг. Гэхдээ би бол бараг явдаггүй л дээ. Надад үнэндээ явах хэрэг байдаггүй. Яагаад гэвэл манай гэрийн ойролцоо дэлгүүр, сургууль, парк, усан сан гэх зэрэг бүх юм байдаг.

^ Манай байшин цэцэрлэг, гражтай.

v Би хөрийнхөө цэцэрлэгт байгаа нь. Би нил ягаан өнгийн богино өмдтэй байна. Бид энд ус цацуулан тоглох их дуртай.





“Энэ зурган дээр би найзуудтайгаа байна. Манайд цэвэрлэг байхгүй учир бид гудамжинд тоглодог. Би судалтай намцтай байна.

Бади

Намайг Бади гэдэг. Би Индонезийн нийслэл Жакартад амьдардаг. Би яг энэ сувгийн хажуу талд байгаа цайрдсан төмрөөр хийсэн байшинд амьдардаг.

Суваг маш бохир. Тэр хог хаягдлаар дүүрэн бөгөөд ус нь үнэртэй байдаг. Зун Жакартад маш халуун. Ус нь сэрүүцэхийн тулд сэлэхүйцээр цэвэрхэн байгаасай гэж би хүсдэг. Гэвч ээж маань ус чамайг өвчлүүлнэ гэж хэлдэг юм.



Газар тариалан, мал аж ахуй эрхлэх нь

Бид иддэг хүнснийхээ ихэнхийг нь газар тариалан, мал аж ахуйгаас авдаг. Тариачдын ургуулдаг үр тариа болон тэдний үржүүлдэг амьтдал цаг агаар, хөрсний үржил шим их нөлөөлдөг. Хойд мөсөн далай нь гадил ургуулахад тийм ч сайхан газар биш. Гэхдээ энэ нь аж ахуйгаас авдаг цорын ганц хүнс биш билээ. Аж ахуй эрхлэгчид мөн хөвөн гэх мэт ургамлыг тарьж ургуулдаг бөгөөд хөнийг ноосыг нь авахын тулд үржүүлдэг.



Мал маллах

Зарим аж ахуй эрхлэгчид малдаа цэнгэг ус, хоол тэжээл олохын тулд нэг газраас нөгөө газар уруу нүүдэг. Үүнийг мал маллах гэнэ. Кени улсын малчид зулгааж авсан бут сөөг, шавар болон амьтны ялгадсаар хийсэн энгийн гэрт амьдардаг. Яагаад гэвэл тэд дахиад л удахгүй нүүнэ гэдгээ мэддэг. Нүүх бүрдээ тэд шинэ гэр барьдаг.

< Энэ Кенийн эмэгтэй ямаа хариулж байна. Түүний авч явж байгаа ишиг магадгүй ээжийгээ алдсан байж болох юм.

> Өвс бэлтгэлийн үед аварга том компаниуд улаан буудайг хадаж, үрийг нь ялгаж авдаг.



Будааны аж ахуй

Дэлхийн хүмүүсийн тэн хагасаас илүү нь өдөр болгон будаа иддэг. Иймээс будааны аж ахуй маш чухал билээ. Энэхүү будааны аж ахуй нь Индонез улсын Бали гэдэг арал дээр байдаг. Будаа нь тутрагын талбай гэж нэрлэдэг талбай дээр ургадаг. Тутрагын талбай толгодын хажууд шаталсан хэлбэртэй байдаг. Борооны улиралд тутрагын талбай үерт автдаг. Бат бөх чулуун хана усыг зогсоож, толгодын дагуу хөрсийг угаагдахаас хамгаалдаг.

< Будааны аж ахуй эрхлэгч талбай дээрээ хогийн ургамал байгаа эсэхийг шалгаж байна.

Ойртоод хар

Дэлхийн далай тэнгисээс жилд наян сая орчим тонн загас барьдаг. Зарим загасчид оордлоо болон гэр бүлийнхэндээ хүрэлцээтэй загас барьдаг. Харин зарим оронд загас агнуур нь томоохон бизнес билээ.



“Японы загас агнуурын завиуд бол нэг ёсны хөвдөг үйлдвэр юм. Тэдний нарийн тор нь хэдэн тонн загас барьдаг. Онгоцны тавцангаас доош загасыг цэвэрлэж хөргөдөг. Энэ нь урт хугацааны далайн аян замд загасыг шинээр нь байлгадаг билээ.

Эрчимт аж ахуй

Эрчимт аж ахуй эрхлэгчид нь газраасаа чадлынхаа хэрээр аль болох өндөр үр ашиг авахын тулд сайн технологи бүхий машин техник, химийн бодисыг ашигладаг. Энэ эрчимт аж ахуй нь Украин улсад байдаг. Үр тарианы талбай нь аварга том бөгөөд тэнд том том машин техникүүд төвөггүйхэн ажилладаг. Тэдгээр машин техникүүд нь олон ажилчны ажлыг маш богино хугацаанд хийж чаддаг.



Хью, Аданна, Даниел нар

Хью

Би Австрали улсын нэгэн маш том хонины фермд амьдардаг. Бид ойролцоогоор гурван мянган хоньтой. Манай хамгийн ойрын хөрш бол машинаар явахад хоёр цагийн зайд байдаг. Хамгийн ойрын сургууль хүртэл надад бас л хол байдаг. Иймээс ээж маань надад гэрээр багшилдаг. Хэрвээ хичээлээ хийхэд тусламж хэрэгтэй бол би хоёр шугамын радиогоор багш нартайгаа харьцаж болно. Би хонины фермдээ амьдрах дуртай. Гэвч заримдаа би бусад олон найзуудтайгаа ч гэсэн уулзахыг хүсдэг.

v Зураг дээр би том ах болох Грэггийн хамтаар хургаа тэжээж байна. Хэрвээ хурганаас маань ондвол ээж түүнийг гэртээ асардаг.



Аданна

Би Нигер улсын жижигхэн аж ахуйн тосгонд амьдардаг. Манайх цөөхөн тооны үнээтэй бөгөөд эрдэнэ шиш, төмс, хүнсний ногоо, гадил жимс ургуулдаг. Идэхээсээ илүүг ургуулах юм бол бид орон нутгийн зах дээр борлуулдаг. Аж ахуй дээрээ бид үнэхээр шаргуу ажиллацгаадаг. Бидэнд трактор байхгүй учир бид бүх ажлыг гараараа хийдэг.

> Ээж надал ямаа саахыг зааж байна. Иймээс би хичээлдээ явахасаа өмнө ямаагаа саачхаж чадна. Би пир пир хийн хувинд орж буй сүүний дуунд дуртай.



Даниел

Би Танзани улсын кофены фермд амьдардаг. Бидний кофены буурцаг дэлхий даяар зарагддаг. Ургац хураалтын үе нь жилийн хамгийн завгүй өдрүүд байдаг. Би сургуульдаа явахын оронд гэртээ туслахаар үлддэг. Эхлээд бид кофены жимсээ бутнаас түүдэг. Дараа нь түүнийгээ сэгсэрч, угааж, дунд нь байдаг буурцгийг нь салж унатал нь хатаадаг.

< Би дүү нар үеэлүүдийнхээ хамт кофены буурцгийг худалдахаасаа өмнө шалгаж байна. Цагаан өнгийн богино ханцуйтай цамцтай нь би.





Эд зүйлс хийх

Дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүс бусдад худалдахын тулд эд зүйлсийг хийдэг. Зарим зүйлсийг гэртээ хийж орон нутгийн дэлгүүр, зах дээр зардаг. Зарим нэг зүйлсийг томоохон




үйлдвэрүүдэд хийж дэлхий даяар борлуулдаг. Энэхүү резинэн нугасыг Хятадад хийсэн бөгөөд Шведийн дэлгүүрт борлуулдаг байна.

Дэлхийн ажилчид

Зарим хүмүүс урчууд байдаг. Тэд модон амьтан, хивсэнцэр, эсвэл сав суулга зэрэг гоё эд зүйлс хийхийн тулд гараа ашигладаг. Уламжлалт урлалын олон арга ухааныг хүүхдүүд зуу зуун жилийн туршид өвлөн авсаар байна. Зарим ажилчид агаарын хөлөг, эсвэл авто машин зэрэг олон эд анги бүхий бүтээгдэхүүний жижиг өчүүхэн хэсгийг хийдэг машин дээр ажилладаг байж болно. Тэд хэзээ ч хийхэд нь тус нэмэр болж буй бэлэн бүтээгдэхүүнээ хардаггүй.

> Борооны шүхэр үйлдвэрлэгчид тэдний хийсэн бүтээгдэхүүн хэзээ ч хэрэглээнээс гарахгүй гэдгийг мэддэг. Дэлхий дээр бороо их ордог газрууд байсаар байгаа тул хүмүүс норохгүйн тулд шүхрийг хэрэглэдэг.

< Энэхүү машины үйлдвэр мэтийн орчин үеийн үйлдвэрүүдэд хүний оронд роботуудыг ашигладаг.





“Би цөхдээ байна (дунд талынх нь). Бид элгээр зүйлүүдээсээ тогосонд хамгийн их дуртай.”

Падма

Намайг Падма гэдэг. Би металаар хээ угалз урладаг. Энэтхэгийн жижигхэн цөхэд ажилладаг. Тэнд би хичээлийнхээ дараагаар болон амралтын өдрүүдэд аав, ах нарынхаа хамт ажилладаг. Бид хээ угалзаа зах дээр борлуулдаг. Энэтхэгээс ямар нэгэн гоё зүйл гэр лүүгээ авч явахыг хүссэн жуулчид олноор нь худалдаж авдаг.

Юста

Миний нэрийг Юста гэдэг. Африкийн эргийн Занзибарын арал дээр амьдардаг. Би дэрсээр хийсэн конус хэлбэртэй хоолны бүтээлэг болох макаваг сүлждэг. Би макаваг хүнсний зүйлийг нар, ялаа зэргээс хамгаалахын тулд ашигладаг. Би макаваг гэртээ зориулж хийдэг. Мөн зарим нэгийг нь буслад борлуулдаг. Миний аав намайг «Чи тосгондоо хамгийн сайн сүлжигч» гэж хэлдэг. Дүү нар маань намайг макава сүлжиж байхыг харах дуртай. Тэд том болохоороо бас л сүлжиж сурна.

Дасгал ажил

Томоохон компаниуд бүтээгдэхүүнээ хүмүүсийг худалдаж авсаар байгаасай гэж сая саяар нь мөнгө зарж, сурталчилгаа хийдэг.

Өөрийнхөө дуртай нэг тоглоомондоо зориулж сурталчилгааны хуудас хийхийг хичээ. Тэр хуудсаа өнгөлөг, хүний нүдэнд тусгахуйцаар хий. Тэрхүү тоглоомыг онцгой болгож буй зүйл нь юу вэ гэдэг талаар бод.



Дэлгүүрээр явж худалдаа хийх

Ихэнх хүмүүс хэрэгцээтэй бүхнээ тарьж ургуулж, хийж чаддаггүй. Иймээс тэд дэлгүүрээс худалдаж авах хэрэг гардаг. Зарим дэлгүүрүүд аварга том байх ба олон янзын эд зүйлсийг худалддаг. Харин зарим нь өчүүхэн жижигхэн байх бөгөөд бяслаг гэх мэтийн зөвхөн нэг л төрлийн зүйлийг борлуулдаг. Чи ямар дэлгүүрээр явах дуртай вэ?

Келвин

Намайг Келвин гэдэг. Би долоо хоног бүр ээжтэйгээ хүнсний их дэлгүүр лүү явдаг. Дүүрээд хүнд болохоор нь би ээждээ түрдэг сагсыг нь түрэхэд нь тусалдаг. Ээж бид хоёр юу авах тал дээр үргэлж санал нийлээд байдаггүй. Би зөгийн балтай, чихэртэй амуу будаанд дуртай. Гэвч ээж тэр миний шүдийг сүйтгэнэ гэж хэлдэг. Хэрвээ би зүтгээд байвал ээж аваад огчихдог.



“Энэ зурган дээр байгаа хятад эмэгтэйчүүд буда худалаачид юм. Тэд замын хажуу талын ширээнээс бензин худалддаг.

v Энэхүү амуу будааны хайршаг нь миний дуртай хүүхэдлэйн киноны баатрын зурагтай байна.





^ Халуун ногоонууд сайхан өнгөтэй байдаг.

Рави

Намайг Рави гэдэг. Аав маань Энэтхэгийн Калькутта хотын зах дээр халуун ногооны лангуу ажиллуулдаг. Халуун ногоог нунтаглаж тавган дээр овоолдог. Ихэнх энэтхэгчүүд хоол хийхдээ халуун ногоо хэрэглэдэг. Иймээс олон хүмүүс манай лангуун дээр ирдэг. Нэг удаа аавдаа тусалж байхдаа би найтаачихсан. Гэтэл өнгө өнгийн нунтууд лангуун дээгүүр цацагдсан. Аавд таатай байсангүй. Би гүйж яваад, аавыг тайвширтал зах дээр нуугдаж байгаад ирсэн.

Дасгал ажил

Ямар нэгэн онцгой баяр болж байгаа гэж бодье. Чи гэр бүлийнхэндээ бэлэг болгон худалдан авах зүйлийнхээ жагсаалтыг гарга. Жагсаалт дээрээ байгаа бүх зүйлийг худалдаж авахын тулд хэчнээн дэлгүүрээр орох вэ?



Дуртай хоол хүнс



Бид бүгдээрээ амьд байхын тулд идэх хэрэгтэй байдаг. Гэхдээ хоол хийх болон идэх нь ч бас хөгжилтэй сайхан байдаг. Дэлхийн янз бүрийн газруудад байгаа хүмүүс мөн олон төрлийн хоол хүнс хэрэглэдэг. Эдгээр хүүхдүүд чамд хамгийн их идэх дуртай зүйлийнхээ талаар өгүүлж байна.

Нок

Намайг Нок гэдэг. Би Тайландад амьдардаг. Би өөрийнхөө оронд ургалаг амттай бүх жимсэнд дуртай. Гэхдээ миний дуртай жимс бол тарвас юм. Тэр чихэрлэг бөгөөд маш шүүслэг байдаг. Би тарвасаа замын хажуугийн жимсний лангуунаас худалдаж авдаг.

Сергей

Миний нэрийг Сергей гэдэг. Би Орос улсад амьдардаг. Миний дуртай идэх юм бол мөхөөлдөс. Жил бүр бид миний төрсөн өдрөөр мөхөөлдөсний дэлгүүрдүү явдаг. Би гаатай, шоколадны амттайд нь илүү дуртай.



Антонио

Намайг Антонио гэдэг. Би Итали үндэстэн бөгөөд пицшанд дуртай. Миний дуртай пицшаны дээр бяслаг, помидор, халуун ногоотой мах байдаг. Бямба гариг бүр авч бид хоёр өдрийн хоолондоо пицца хийдэг.



Жордан

Намайг Жордан гэдэг. Би Кени улсад амьдардаг. Миний дуртай хоол бол амтат төмстэй тахианы жигнэсэн мах. Энэ хоолны бараг бүх орц нь манай гэрийн аж ахуйгаас гардаг. Яагаад гэвэл бид тахиа үржүүлж, ногооныхоо талбайд амтат төмс тарьдаг.

Дасгал ажил

Чиний иддэг бүх зүйл чиний өөрийн чинь улс оронд хийгддэггүй. Зарим нь дэлхийн ногоо өнцгөөс ирдэг. Хөргөгчиндоо болон шүүгээндээ байгаа хүнсний зүйлүүдийг хар даа. Шошгууд нь эдгээр хүнс хаанаас гаралтайг чамд хэлж өгнө. Хамгийн хол зайд авьж ирсэн хүнсний зүйл аль нь болохыг харахын тулд дэлхийн газрын зургийг үз.



< Би амтат төмсөө газраас ухаж гарган авч байна.

Бусдын төлөө ажиллах

Олон хүмүүс бусдад зориулж эд зүйлс хийдэг ажилтай байдаг. Хэчнээн хүн чамд зориулж эд зүйлс хийдэг талаар бод. Багш, шүдний эмч, телевизийн хүүхдийн нэвтрүүлгийн ажилчид зэрэг нь зөвхөн нэг хэсэг нь юм. Бидний төлөө хүмүүсийн хийдэг зарим нэг ажлуудын талаар энд өгүүлж байна.



^ Биднийг өвдөх буюу шанахлахад эмч, асрагч нар сувилдаг. Энэ хүү модноос унаад гараа хуталжээ. Эмч түүнд шохой тавьж байна.

< Жүжигчид болоод урлагийн ажилтнууд биднийг хөгжөөж, заримдаа гайхширал төрүүлдэг. Эдгээр жүжигчид нь хүмүүст зориулж гудамжинд үзүүлбэр тоглож байна.




Ойртоод хар

Хүмүүсийн хийдэг байсан олон ажлыг одоо машин техник хийдэг болжээ. Жишээлбэл чи мөнгөө банкинд очиж авахын оронд гудамжинд байдаг бэлэн мөнгөний машинаас авч болно.



v Хэрвээ байшинд гал гарвал галыг унтраах гэж гал сөнөөгчид удахгүй ирдэг. Тэд байшинд орохын тулд сүх болон царил ашигладаг бөгөөд утаатай агаар амьсгалахаас сэргийлж маск хэрэглэдэг байна.



^ Автобусны жолооч нар биднийг нэг газраас нөгөө газарт аваачдаг. Пакистанд байдаг энэхүү автобусыг гайхамшигтай өнгө будаг, зургаар чимэглэсэн байдаг. Хүн дүүрэн суусан энэ автобус орон нутгийн захад байрладаг суурин уруу явдаг.

v Цагдаагийн ажилтнууд бидний аюулгүй байдалд анхаарал тавьдаг. Тэд хүмүүсийг хууль зөрчихгүй байлгах тал дээр хичээж ажилладаг бөгөөд зорчсон хүнийг баривчилдаг.



Хүүхдүүд сургууль дээр

Чи сургуульд явдаг уу? Ихэнхи хүүхдүүд сургуульд явдаг. Дэлхийн өнцөг булан бүрт янз бүрийн сургуулиуд байдаг. Судалдаг хичээл, сургуульдаа явдаг цаг, сургуулийн барилга зэрэг нь бүгдээрээ чиний хаана амьдарч байгаагаас хамаардаг.

> Би сургууль дээрээ байна. Би үсэндээ хурц ягаан өнгийн тууз зүүсэн Рупати гэдэг охин дүүгийнхээ хажууд сууж байна.

Абдул

Намайг Абдул гэдэг. Би Бангладешт амьдардаг. Бид маш их азтай. Яагаад гэвэл манай тосгонд сургууль байдаг. Харин олон тосгонд сургууль байдаггүй. Манай сургууль жаран хүүхэдтэй боловч ганцхан багштай. Бид уншиж, бичиж, тоо болоход суралцдаг. Мөн түүнчлэн аж ахуй эрхлэх болон эрүүд мэндийн хичээлүүд ордог. Хичээл хэтэрхий халуун болохоос өмнө эрт эхэлдэг. Хичээл үдийн хоолны цагаар дуусдаг ба үдээс хойш эцэг, эхийнхээ эрхэлдэг аж ахуй дээр ажилладаг. Би гэрийнхэн дотроосоо ганцаараа уншиж чаддаг. Би эцэг эхдээ уншиж тусалдаг. Би тэдэнд хэрэгтэй байж чаддагаараа маш их бахархдаг.

Дасгал ажил

Абдул, Анна нарт сургуулийнхаа нэг өдрийн талаар захидал бич. Тэд нарт хичээл сургуулийн юу нь таалагдсныг захидалдаа бич. Танай сургуульд тэд явна гэж чи бодож байна уу?





Анна

Намайг Анна гэдэг. Би АНУ-д амьдардаг. Өглөө бүр би сургуульдаа шар автобусаар явдаг. Ихэнх өдрүүдэд бид унших, бичих, тоо бодохоос гадна дууны, зургийн, биеийн тамирын, газар зүйн хичээлүүд үздэг. Миний дуртай хичээл бол зургийн хичээл юм. 11.30-д би авчирсан хоолоо идэж дараа нь дахиад 02.30 хүртэл хичээллээд гэр лүүгээ явдаг. Хичээлийнхээ дараа би телевизор үзэх юм уу, дүүтэйгээ тоглох дуртай.

> Би сургууль дээрээ багшийнхаа хажууд сууж байна.



^ Ус авах нь маш чухал ажил байдаг. Гэхдээ хамгийн ойр орших худаг уруу нэлээд хол алхаж очдог. Гвинейн энэ хүүг ээж нь ус авчруулахаар явуулжээ.

Ойргоод хар

Абдул болоод түүний дүү нар шиг дэлхийн олон хүүхдүүд ээж аавдаа тусалж ажил хийх шаардлагатай байдаг. Энэ нь ихэнхдээ тэд хичээл сургуулиа орхих хэрэгтэй гэсэн үг юм.



^ Энэ Морокко хүү санхиаар хийсэн эд зүйлсийг чимэглэх ажилдаа маш шургуу зүтгэлэг.

Хүүхдүүд тоглож байна

Хичээлээ тараад болон гэрийнхээ даалгаврыг хийчхээд чиний хийх хамгийн дуртай зүйл чинь юу вэ? Хөгжим сонсохоос эхлээд амьтны хүрээлэн явах хүртэл чөлөөт цагаараа хийх болон үзэх олон хөгжилтэй зүйлс байдаг. Эдгээр хүүхдүүд чамд өөрсдийн хийх хамгийн дуртай зүйлсийнхээ тухай ярьж өгөх болно.

Жак

Намайг Жак гэдэг. Би хөл бөмбөг тоглох дуртай. Би Гаити улсын Порт-О-Пренс гэдэг хотод амьдардаг. Манай гэрийн ойролцоо хөл бөмбөгийн талбай байдаггүй учир гудамжинд тоглодог. Би хичээлийнхээ дараа бөмбөг харагдахааргүй орой болтол тоглодог. Нэг л өдөр өөрийн гэсэн тохирсон ултай хөл бөмбөгийн гуталтай болохыг хүсдэг.

> Би Бертранд гэдэг найзтайгаа хөл бөмбөг тоглож байна. Хөл нүүгэн байгаа нь.



Мигель

Намайг Мигель гэдэг бөгөөд Мексикт амьдардаг. Би дүү нартайгаа телевизийн уралдаан тэмцээнт хөтөлбөрүүдийг үзэх дуртай. Хөтөлбөрүүдийн ихэнхийг АНУ-д хийдэг бөгөөд Испани хэлнээ хөрвүүлсэн байна. Хүмүүсийн ярьж байгаа үг амныхаа хөдөлгөөнтэй таарахгүй байгааг харж болно.

< Манай гэр ганцхан өрөөтэй учир телевизор үзэхдээ зарим нь орон дээрээ суудаг.



Ойртоод хар

Энэ өдрүүдэд олон гэр бүл амралтаараа гадаад орон уруу явдаг. Энэ нь өөр өөр орноос ирсэн хүүхдүүд бие биенээ мэддэг болно гэсэн үг. Энэ бол Мороккод амарч байгаа Борисоос ирсэн захидал юм.

*Хүндэй Сибериа,
Эдэр цагайг сэдэглэж өлсөвчлэж байлаа. Арав сардаа
хөдөрчлөх бэлэн. Жэр нэрлэлтэй дууны хийдэг.
Аравил сар нь хайртай дээдсөртэй. Манх талрууруу
нэрээр нэгддэг уявдга. Эндэгийнхэн хөдөдөг
талруу хөдөдөг. Арав нүүддэг их дуртай.
Хайртай би нийлэн г их дуртай бич.
Хайртай нүү.
Борисоос тавь.*

> Усанд тоглох дуртай юу? Ихэнх хүүхдүүд дуртай байдаг. Хаашаа ч явсан усанд сэлэх, шумбах, савчих нь сайн дасгал бөгөөд үнэхээр хөгжилтэй байдаг. Зарим бассейн нь хиймэл суваг гэж нэрлэгддэг аварга том усан гулгууртай байдаг. Энэ нь чамайг усан сан уруу түлхийгээ оруулдаг.



Уильям

Намайг Уильям гэдэг. Би Англи улсад амьдардаг. Миний дуртай аялал гэвэл зун болгон манай сууринд болдог үзэсгэлэн яармагт очих юм. Би үхлийн гулсуурт хамгийн их дуртай. Энэ үнэхээр аймшинтай. Буухдаа би өвдөж, толгой эргэсэн мэт болдог. Гэхдээ би үүнийг тоодоггүй. Өнгөрсөн жил аав самар нууж тоглодог тоглоомоос аварга том ягаан өнгийн бамбарууш хожсон.

v Би эргэдэг сандлын өмнө хөл бөмбөгийн Арсенал багийн өмсгөлтэй зогсч байна.



Бидний итгэдэг зүйл

Дэлхийн олон хүмүүс шашин шүтдэг. Ихэнх шашнууд өдөр тутмын амьдралын цаана үзэгдэж харагддаггүй хүч байдаг гэж сургадаг. Энэ хүчиндээ ихэвчлэн бурхан буюу бурхад гэсэн нэр өгдөг. Шашнууд гол төлөв юу зөв, юу буруу талаар сургасан дэг ёс, сүсэг бишрэлтэй байдаг. (яагаад бид төрдөг, үхсэний дараа дахин төрдөг эсэх гэх мэт)

Христийн шашин

Христийн шашинтнууд хоёр мянга гаруй жилийн өмнө амьдарч байсан Есүс Христийн сургаалыг дагадаг. Есүс нь бурхны хүү байсан гэж тэд итгэдэг. Тэдний ариун нандин сургаал нь Библи юм. Энэ ном нь Есүс тэнгэрийн орноо очиж бурхан болохоосоо өмнө газар дэлхий дээр яаж ирсэн, хэрхэн загалмайд цовдлогдож үхсэн ба гурван өдрийн дараа хэрхэн дахин амилсан талаар өгүүлдэг. Есүс нь бурхан бол хүмүүст хайртай төдийгүй ямагт тэднийг уучлахад бэлэн байдаг гэж сургасан. Бүтэн сайн өдөр олон христэд итгэгчид хамтдаа мөргөл үйлддэг.



^ Миний нэрийг Софи гэдэг. Христосын баяраар манай сургууль дээр Есүс хэрхэн төрсөн талаар жүжиг тоглодог. Би Есүсийн ээж Мери болж байгаа нь. Энэ нь тус жүжгийн хамгийн чухал хэсэг юм.

Йудейн шашин

Еврейчүүд нэг л бурхан байдаг гэж итгэдэг. Тэд хэдэн мянган жилийн өмнө бурхан өөрсдийг нь өөрийн сонгосон хүмүүс байх болно гэсэн гэрээ байгуулсан хэмээн итгэдэг. Хариуд нь тэд бурхны хуудлыг дагаж мөрдөхөө амласан. Энэ хууль нь Тора хэмээн нэрлэгддэг ариун сургаалд нь бичээстэй байдаг. Баасан гаригийн оройноос Бямба гаригийн өглөө хүртэл Саббат буюу ариун өдөр гэж нэрлэгддэг амралт, мөргөлийн тусгай өдөртэй байдаг.

< Ханукка гэдэг нь еврейчүүдийн баяр наадам юм. Найман өдрийн турш өдөр болгон хүүхдүүд Хануккагийн лааны тавиур дээр лаа асаадаг.



v Намайг Махмуд гэдэг. Баасан гариг бүр аав дүү нарынхаа хамтаар сүмд залбирал үйлдэхээр явдаг. Орохоосоо өмнө би өөрийгөө угааж, гутлаа тайлдаг. Би сүмд байна. Залбирал эхлэхийг хүтээж шалан дээр сууж байна.

Лалын шашин

Лалын шашинг дагадаг хүмүүсийг Мусальманчууд гэдэг. Иудей болон Христийн шашинтнуудтай адил лалын шашинтнууд өөрсдийнх нь нэрлэдгээр Аллах хэмээх бурхныг шүтдэг. Тэд Аллах 1300 жилийн өмнө Арабт амьдарч байсан зөнч Мухамедаар дамжуулан газар дэлхийн хүмүүстэй ярьдаг гэж итгэдэг. Аллахын үг Коран гэж нэрлэдэг ариун номонд бичигдсэн байдаг. Лалын шашинтны хүүхдүүд Коран судрыг уншиж цээжлэхийг заалгадаг.





< Миний нэрийг Лувсан гэдэг. Би арван настай. Би лам болохоор суралцаг бөгөөд буддын сүмд амьдардаг. Хэрвээ би лам болохоо болих юм бол буцаад гэртээ очиж амьдрах болно.

^ Миний амьдардаг сүм Төшөд байдаг.

Буддын шашин

Буддын шашны бурхан гэдэг ойлголт бусад шашныхтай адилгүй байдаг. Тэд 2500 жилийн өмнө амьдарч байсан Буддагийн сургаалыг дагадаг. Будда нь аминч үзэл нь хүнд өвчин шаналал, зовлон зүдгүүр авчирдаг гэж сурган улс орноор аялсан. Буддын шашинтууд бодож, ярьж, хийж байгаа бүх зүйлдээ сайхан сэтгэлээр хандахыг хичээх ёстой. Бясалгал хийх нь тэдэнд үүнийг хийхэд тусалдаг аж. Тэд чимээгүй суугаад оюун санаандаа дандаа ариун юм бодохыг хичээдэг.

Хинду шашин

Хинду шашинтнууд олон бурхныг тахидаг. Тэд хүн үхэхэд өөр биед эргэн төрдөг гэж итгэдэг. Сайн хүмүүс урьдынхаасаа илүү сайхан амьдралд эргэн төрөх болно. Харин бусдыг гомдоосон хүн илүү хэцүү амьдралд төрж болох юм. Хинду шашинтнууд гэртээ байдаг шүтээнээ тахиж, мөн сүмд очдог. Хинду шашин бол Энэтхэгийн гол шашин юм.

> Намайг Санжая гэдэг. Бид Энэтхэгийн баруун хойд хэсэгт амьдардаг. Холн гэдэг нь Хиндугийн хаврын баяр юм. Бид бие бие үрүүгээ хурц өнгөтэй нунтаг цашан, усаар шүрддэг. Энэ зурган дээр би үеэлүүдийнхээ хамтаар савтай ус барин зогсож байна. Би дунд нь зогсож байгаа хамгийн жижиг нь.



Бусад шашин

Дэлхий дээр өөр олон шашин байдаг. Зарим нь сая сая сүсэгтэнтэй байхад зарим нь хэдхэн зуун сүсэгтэнтэй. Сикхүүд нэг бурханд итгэдэг. Тэд бурхан бүх юманд байдаг бөгөөд бүх хүмүүс адил тэгш байдаг гэдэгт итгэдэг. Сикхийн сүмийг Гурдварас гэнэ. Тэд нарын ариун номыг Гуру Грант Сахиб гэх бөгөөд тэрээр сүмийн шүтээнд халгалагддаг.

Таогийн шашин нь Хятадын шашин юм. Таогийн шашинтнууд олон бурханд итгэдэг бөгөөд байгальтайгаа зохицон амьдрахыг хичээдэг.

v Миний нэрийг Ёоко гэдэг. Манай гэрийнхэн Шинто шашныг шүтдэг. Үхсэн ч гэсэн байгаль, амьтад, хүмүүсийн дунд олон бурхан байдаг гэж тэд итгэдэг. Энэ зураг дээр би шүтээн гэж нэрлэдэг ариун газарт «Миний шалгалтанд бурхан тулаасай!» хэмээн мөргөн гуйхаар ирээд байгаа нь энэ.



Хамтдаа тэмдэглэцгээе

Бүх дэлхийн хүмүүс онцгой үйл явдлуудыг сайхан хувцаслаж, тусгай хоол идэж, дуулж бүжиглэж, цэнгээн наадам зохион тэмдэглэдэг. Үүнд төрсөн өдөр, байгалийн, эсвэл шашны баярууд орно. Энэ хүүхдүүд чамд өөрсдийнхөө дуртай баяруудын тухай ярих болно.



“ Би багт наадмын гоёлоо өмсөөд зогсож байна. Би баярын жагсаал болоод бүжгэнд маш их дуртай.

Мария

Намайг Мария гэдэг. Бразилийн Рио Де Жанейрод амьдардаг. Миний дуртай баяр бол манай хотод жил болгон болдог багт наадам юм. Тус багт наадам нь Христийн шашинтнуудын мацаг барьдаг үе болох «Лент»-ийн өмнө болдог найр наадам байсан. Энэ өдөр сонирхол татам гоёлын хувцас өмссөн бүжигчид гудамжинд жагдаг бөгөөд маш их дуу чимээ сэтгэл хөдөлгөм байдаг билээ.

Дасгал ажил

Амттанаар дүүргэн чимэглэсэн бөмбөлөг болох «пината»-г хий. Мексикт төрсөн өдрөөр ийм бөмбөлгийг хийж өлгөөд, хүүхдүүд саваагаар түүнийгээ хагалдаг. Энэ бөмбөлгийг загас болгохын тулд эхлээд хийсэн бөмбөлгөө шуумлаар бүр. Шуумлыг хатмагц бөмбөлгийнхөө хийг гарга. Тэгээд нэг бүдүүн захад нь ам гарга. Хатуу шаасар хийсэн сүүд, сэрвээ нэмээд уях уяагаа бэхэл. Одоо түүнийгээ хурц тод өнгөөр будаж амттанаар дүүргэ.





Халловин буюу сүнсний баяр
АНУ-д 10 сарын 31-нд болдог Халловины баяр нь маш хөгжилтэй баяр юм. Энэ нь тэр шөнө үхэгсдийн сүнс харагддаг хэмээн итгэж байсан үеэс гаралтай. Хүмүүс шулмас шиг хувцаслаж, хулуутаар дэнлүү хийдэг.

v Хятадын шинэ жил гэж том баяр болдог. Бээжингийн гудамжинд тэсэрдэг цацруулагч тавьж, тос шаасан лууг гудамжаар авч явдаг.

^ Нүүр шарай сийлж, дотор нь лаа байрлуулсан дэнлүүнүүд нь аймшигтай харагддаг.



Хелена

Намайг Хелена гэдэг. Би Шведэд амьдардаг. Миний дуртай баяр бол 12-р сарын 13-нд болдог Санта Лусиягийн баяр юм. Энэ өдөр охидууд бид цагаан өнгийн өмсгөл өмсч, лаан титмийг толгой дээрээ тавьдаг. Гудамжаар хоороор дуудан удаан явдаг. Жагсаалын дараагаар бид гүргэм болон үзэмтэй хийдэг «Луссикатт» гэгддэг жижигхэн талх иддэг.

> Энд би Санта Лусия шиг хувцаслагдаад байна. Тэрээр гэрлийг нисээч гэгээнтэн юм.




Бидний ирээдүй

Хүн болгон ирээдүйнхээ талаар мөрөөддөг. Дэлхийн ядуу хэсэгт ч хүүхдүүд хүрэлцээтэй идэх хоолтой, уух цэвэр устай байгаасай гэж хүсдэг. Энэ номон дээр гарсан хүүхдүүд өөрийнхөө хүсэл мөрөөдлийн талаар ярьж байна.



Лувсан

Би өөрийн амьдралынхаа туршид сүмдээ байж, буддын шашны сайн лам болох юм сан гэж боддог. Гэр бүлийнхнийгээ санах боловч хүн бүхэн надад сайхан сэтгэлээр ханддаг бөгөөд надад хэрэгтэй бүх юм энд бий. Хэрвээ би сайн сурч, бясалгалаа сайн хийх юм бол магадгүй нэг өдөр сүмийнхээ тэргүүн нь байхуйц хэмжээний ухаантай болох болно.



Софи

Би сургууль дээрээ Христийн төрсөн өдрийн жүжигт тоглосон маань надад маш их таалагдсан. Би жүжигчин болохыг хүсч байна. Том болоод жүжгийн тусгай сургуульд явах хэрэгтэй болох нь. Би кинонд тоглож, баян бөгөөд алдартай кино од болохыг хүсч байна. Би Холливудад очиж, тэнд усан сантай том байшинд амьдарч ч болох юм.





Хью

Том болоод би онгоцоор явдаг эмч болно. Австрали улсад онгоцоор явдаг эмч нар маш чухал байдаг. Эмнэлэггүй газар хүн өвдвөл тэр онгоцоор нисч очдог. «Нисдэг эмч» миний дүүгийн олгой нь хагарахад ирж амийг нь аварч байсан. Эмч болохоосоо өмнө би сайн суралцаж маш олон шалгалтуудыг өгөх хэрэгтэй болно.



Рави

Том болоод би аав шигээ зах дээр ажиллахыг хүсч байна. Гэхдээ би халуун ногооны оронд гоё үнэт зүйл борлуулахыг хүсч байна. Магадгүй нэг өдөр би өөрийн гэсэн дэлгүүртэй болж Калькуттагийн баян хатагтай нарт алт мөнгөн бугуйвч зарж байх болно.



Аис

Том болоод би дэлхийгээ цэвэр байлгахад тусална. Бид дэлхийгээ хамгаалж, гол мөрөн, далай тэнгисээ хүмүүсийн зүгээс бохирдуулах явдлыг зогсоох нь маш чухал гэж би боддог. Зарим амьтад удахгүй устана гэдэг нь маш гунигтай хэрэг юм. Би ийм зүйл тохиолдох явдлыг зогсоохыг хүсч байна.



Баримт мэдээлэл

Африк

■ Кени улс



Нийслэл хото: Найроби
Гал явцаг: Христийн шашин, африкийн удмылжлал

Кени улс нь Зүүн Африкт байдаг. Эрт ханшраа халуун, бороо ихтэй байдаг ч их газар дээрээ ядуу хурдтай байна. Ууланд шай болон кофе зэрэг үр тариаг тарьж уруудаг. Олон зэргэ амьдлан гэр болсон Кенийн их талд жуулчид очноддог.



■ Нигер



Нийслэл хото: Агадес
Гал явцаг: Ламин шашин, Христийн шашин, африкийн удмылжлал

Нигер улс нь Баруун Африкт оршдог. Африкийн бусад орнуудад бодвол олон хүрүү амьдардаг. Нигер улс сайн тариалангийн талбай, газрын тосгой учир хамгийн баан улс байж болноор байна. Гэвч мүү засгийн газар, дайныг болж ард иргэд нь ядуу хэвээр л байсаар байна.

■ Өмнөд Африк



Нийслэл хото: Кейп Таун, Претория, Блэмфонтейн
Гал явцаг: Христийн шашин, Африкийн удмылжлал

Өмнөд Африк бол Африкийн хамгийн баан орон юм. Тэнд уул нурууд, дунд цэнгэгий мөчлөг, тал нуга үзэгдэлтэй далайн эргийн газрууд бий. 1994 оныг хүртэл Өмнөд Африкийн шалан ардчууд л зохион сонгуульд оролцдог байжээ. Тэгвэл өнөөдөр ардчилал эрх босооро бай болдог байна.

■ Танзани



Нийслэл хото: Додома
Гал явцаг: Христийн шашин, Ламин шашин, Африкийн удмылжлал

Танзаника ардын улс Энэтхэгийн далайн нэгэн арал Занзибартай нэгдэхэд Танзани улс бий болжээ. Тэрээр нэгэн арлаар хүрээлэгдсэн үзэгдэлтэй эргтэй билээ. Эн газар дээр нь дэлхийн хамгийн алдартай байгалийн нөөц газрын нэг болон Серенгетиин өвсгөрөг гэж тал газар байдаг.

Австралази

■ Австралази




Австрали
Нийслэл хото: Канберра
Гал явцаг: Христийн шашин

Австрали улс өмнөд Номхон далайн нэгэн томоохон улс билээ. Тус улсын дунд хэсэгт маш халуун, хурдтай байдаг учир ихэнх австраличууд эргээр амьдардаг. Ягаад гэнэд үүсгийн нэгдэл Австралид мянга мянган жил амьдарсаар иржээ. Гэхдээ сүүлийн 200 жилд Европ, Азийн хүмүүс ирж энд амьдарч байна.




Умард ба Өмнөд Америк

■ Бразил



Нийслэл хото: Бразилиа
Гал явцаг: Христийн шашин
Бразил нь өмнөд Америкийн хамгийн том улс юм. Дэлхийн хамгийн том халуун бүсийн чийг ан удааг ой тэнд байдаг. Бразил Португаль хариуцдаг байсан. Иймээс хүмүүс нь Португаль хэлээр ярьдаг. Бразилчуудын ихэнх нь эрт орчмын хүн ам ихтэй хотуудад амьдардаг.

■ Канад



Нийслэл хото: Оттава
Гал явцаг: Христийн шашин
Канад нь дэлхийн хоёр дахь том улс. Гэхдээ ихэнх нь хүн амьдрахад янздуу хүйтэн эсвэл хэтэрхий ууларгаг байдаг. Канадчуудын дөрөвний гурав нь өмнөд хэсгийн хотуудад амьдардаг. Канад улс Англи, Франц гэсэн албан ёсны хоёр хэлтэй.

■ Гватемала



Нийслэл хото: Гватемала хот
Гал явцаг: Христийн шашин

Гватемала улс нь Төв Африкт оршдог. Ихэнх хүмүүс газар тариалан эрхэлдэг. Кофеин урмаал, гадал жимс, жонзон, засан чигэр, будам тариалдаг. Гватемала нь олон газар мэдээт, галт уул, салмагд нэрвэгддэг.



■ Ганти



Нийслэл хото: Паро-О-Древо
Гал явцаг: Христийн шашин, -сүтүүр- буюу африк, сарматийн шашин

Ганти нь дундаар Карибын тэнгисийн арал улс юм. Ихэнх гантичууд газар тариалан эрхэлдэг. Гэхдээ газар нутаг нь газар тариалан эрхэлдэг тийм ч сайн бий. Гантичууд Франц, Крөөд гэгддэг Франц хэлтэй өөрсдийн хувьсбар ярьдаг.

■ Америкийн Нэгдсэн Улс (АНУ)



Нийслэл хото: Вашингтон
Гал явцаг: Христийн шашин
АНУ нь дэлхийн хамгийн баан, хамгийн хүчтэй орон. Америк үндэслэгчид Кана-малд үндэмнээс эхлээд компьютер зэрэг бүтээгдэхүүнүүдийг дэлхийн улс орон бүр борлуулдаг. Сүүлийн 400 жилийн өмнөөс энд ирж суурьшиж амьдарсан хүмүүс баяг бүх америкчуудын овог нь юм. Ихэнх хүмүүс далайн эргийн томоохон хотуудад амьдардаг.

Ази

■ Бангладеш



Нийслэл хото: Дакка
Гал явцаг: Ламин шашин, Хиндү шашин
Бангладеш нь нийслэлг орон билээ. Энэ нь дэлхийн хамгийн их хүн амтай улс орны нэг юм. Ихэнх хүмүүс нь газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг. Жал бүр борооны улиралд (6-10 дугаар сар) Бангладешийн гурван том гол үерлэж олон хүмүүс гэр орон, мал, үр тарианыгаа алддаг.



■ Хятад



Нийслэл хот: Бээжин
Гал явцаг: Байгууль

Хятад улс нь маш өргөн уудам газар нутагтай орон юм. Түүний хэмжээ нь бараг Европыг бүтгээр нь авчигайт тэнцэх ба дэлхийн дэл ч орноос илүү тийм их хүн амтай. Хятад улс олон янзын явцаг нутаг, уур амьсгалтай. Тэнд мөнх цас уус, мэлүү бүсийн ариун ч байдаг.

■ ЭНЭТХЭГ



Нийслэл хот: Нью Дели



Гал явцаг: Ханду явцаг, Лалын явцаг

Энэтхэг нь Азийн томоохон улс орны нэг юм. Тэр бум цагаан хүн энэ улсад амьдардаг. Ихэнх хүмүүс махны төстэй арьсаар газар тариалан эрхэлдэг. Зүүн нь маш халуун болон 6-9 сарын хооронд ууршмал салханы нөлөөгөөр ихэнх нутагтар бороо ордог.

■ Индонез



Нийслэл хот: Жакарта
Гал явцаг: Лалын явцаг

Индонез улс 12677 арван бүтэц боловч хүн амын талж илүү хүн нь Ява хэмээх ганцхан арал дээр амьдардаг. Халуун, чийгтэй шиг агаартай. Энэ нь тариалан эрхэлгчдэд буцаагч ургуулахад сайн нөхцөл бүрдүүлдэг. Буцаа нь тус улсын хүн амын үндсэн хүрээ юм.

■ Монгол



Нийслэл хот: Улаанбаатар
Гал явцаг: Бүрдэн явцаг

Монгол улс нь Ази тивд ордог. Олон монголчууд нутгийнхаа дунд хэсэгт, тэд газраараа мал маллан амьдардаг. Монголд зүүн нь халуун, бөтөнч байх ба өвөл нь урь, хүйтэн байдаг.

■ Орос



Нийслэл хот: Москва
Гал явцаг: Христийн явцаг

Орос орон бол дэлхийн хамгийн том газар нутагтай улс юм. Ихэнх хүмүүс нь тариалангийн талбай сайтай, дулаан шиг агаартай улсынхаа баруун хэсгээр амьдардаг. Зүүн хэсэгт нь Сибирь байдаг. Энэ нь өргөн уудам нутагтай, цоонон хүн амьдардаг хүйтэн газар юм.

■ Саудын Араб



Нийслэл хот: Эр-Рияд
Гал явцаг: Лалын явцаг

Саудын Араб нь үрсэндээ элсэн нэг юм. Нутгийн дунд хэсэгт нэлээд тариалангийн талбай байх боловч бороо бага ордог учир уур тарва ургуулахад хэцүү. Лалын явцагын зөвч Мухаммед Саудын Араб төрсөж. Энэ улс бол маш байр. Учир нь тэд маш их газрын төс борлуулдаг юм байна.

■ Тайланд



Нийслэл хот: Бангкок
Гал явцаг: Бөхөн явцаг

Тайланд улс нь Зүүн Азины Азийн мэлүү бүсийн орон. Жалын ихэнх хугацаанд тэнд халуун, бүтэнч байх ба маш их бороо ордог. Энэ нь будаа тарьж ургуулах таатай нөхцөлөөг бүрдүүлдэг. Тайланд улс дэлхийн будаа экспортологч орнуудын хамгийн их будаа борлуулдаг улс юм.

■ Турк



Нийслэл хот: Анкара
Гал явцаг: Лалын явцаг

Туркийн ихэнх хэсэг Азид байдаг. Гэхдээ зүүн зах нь Европт ордог. Турк улсын төв хэсэг нь тата, өвөрмөц газар байх ба газар нь тариалан эрхэлдэг сайн байдаг. Мөн олон жуулчид Туркийн өмнөд хэсгийн наран шарагтан газруудад алддаг.

Европ

■ Европ



Нийслэл хот: Рим



Гал явцаг: Христийн явцаг

Гал явцаг: Христос цагаан Итали улс нь Өмнөд Европын орон юм. Умард хэсэгт нь хүн ам, мал маллохон итгэл олон хотууд, төм үйлдвэрүүд байрладаг. Харин өмнөд хэсэгт хүмүүс аж ахуй эрхэлдэг. Түүний хуучны үзэгслэнгй барилгууд, урлаг зэргийг нь үзэхээр жуулчид энэ оронд их ирдэг.

■ Норвеги



Нийслэл хот: Осло
Гал явцаг: Христийн явцаг

Норвеги нь Хойд Европын улс юм. Норвегийн хойд хэсэг нь Хойд Атлант Далайд оршдог. Газрын ихэнх нь ой мэлээр бүрхсэн ууларга нутагтай. Ийнхүү тэнд олон фермууд байдаг. Норвегид олон хүн загасны аж ахуй эрхэлдэг.

■ Испани



Нийслэл хот: Мадрид
Гал явцаг: Христийн явцаг

Испани нь Баруун Өмнөд Европын хамгийн том орны нэг. Ихэнх нутаг нь модтой том тал бөгөөд зүүн нь агам халуун, өвөл нь тэгшн хүйтэн байдаг. Испанийн халуун дун, эхлэж наран шарагтан газруудад сонирхма олон жуулчид ирдэг.

■ Швед



Нийслэл хот: Стокгольм
Гал явцаг: Христийн явцаг

Швед нь хойд Европын улс бэлтэ. Хойд хэсэг нь хойд туйлд ордог боловч өмнөд хэсэг нь дулаантар бөгөөд газар тариалан эрхэлдэг сайн. Тус улсын дунд хэсэгт олон үйлдвэрүүд байдаг бөгөөд авто машин, компьютер зэргийг үйлдвэрлэдэг.

■ Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс



Нийслэл хот: Лондон
Гал явцаг: Христийн явцаг

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс нь Англи, Шотланд, Велс, Умард Ирландын бүрддэг. Хэцүү нутаг нь ууларга, тэгш, намгаарга газруудыг хамардаг. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын ард иргэд хот суурингуудад амьдардаг.



Индекс

А

Америкийн нэгдсэн улс 6, 18, 26, 33, 41, 44
Абдул 7, 32
Африк 10, 12, 23, 25, 29, 33, 44
Австралази 44
автобусны жолооч 31
авто машин 17, 24
Аданна 7, 23
Ази 44-45
аж ахуй эрхлэх 20-21, 22-23
амьтад 14, 20, 22-23
амттанаар дүүрэн чимэглэсэн бөмбөлөг. 40
Аяс 7, 8, 43
Англи 10, 13, 35
Антонио 7, 29
Анна 6, 33
Ажил 30-31, 32-33

Б

Бали 21
Бангладеш 7, 32, 44
Багш 30, 32-33
Бади 7, 19
Багт наадам 40
Баяр 9, 36, 40-41
Бээжин 41
Библи 36
Борнео 7, 9
Бомбей хот 10
Ботсвана 7, 12, 44
Будда 38
Бразил улс 6, 40, 44
Буддын шашин 38, 42
Бясалгал 38
Бохирдол 17, 19, 43

Будаа 21
Бичих 32-33

В

Вики 6, 8-9
Виллиам 7, 35

Г

Гэр бүл 8-9
Гал сөнөөгч 31
Гэр 11
Герман 35
Гватемала 6, 15, 44
Гвиней 33
Гаити 6, 34, 44
Гэр орон 9, 10-11, 12, 18, 19, 34
Гулгах 7, 14

Д

Даниел 7, 23
Дэлгүүр 15, 24-25, 26-27, 30

Е

Европ 45
Есүс христ 36
Есүс христийн мэндэлсэн өдрийн жүжиг 36

Ё

Ёоко 7, 39

Ж

Жакарта 7, 19
Жак 6, 34
жүжгийн 42
жүжигчид 30

З

Завин сууц 10
Загасны аж ахуй 14, 21

Занзибар 7, 25
Захын хороолол 18
Зах 15, 25, 27
Зах 27
Зул сар 9, 36

И

Индонез 7, 19, 21, 45
Инис 7, 13
Итали 7, 17, 29, 45
Испани 7, 13, 45
Их Британи, умард Ирландын нэгдсэн вант улс 7, 10, 11, 35, 45

Й

Йордан 7, 29
Йудейн шашин

К

Калькута 7, 27
Канад улс 6, 9, 44
кофе 23
компьютер 30
Краал 12
Кени 7, 20 26
Келвин 6, 26
Кристин 7, 14
Коран 37

Л

Лондон 10
Лам 38, 42
Лалын шашинтнууд

М

Мал маллах 20
Мусальманчууд 37
Мацаг барих өдөр 40
Махмуд 7, 37
Машин техник 24, 30
Марио 6, 15
Мария 6, 40

Мехико 6, 34, 40
Монгол улс 7, 11, 45
Мигель 6, 34
Мосис 7, 12
Морокко 33, 35
Мухаммед 37

Н

Нисдэг эмч 43
Нигер 7, 23, 44
Нок 7, 28
Норвеги 7, 14, 45
Ноос 20

О

Орос улс 7, 11, 28, 45
Оюун 7, 11

Ө

Өмнөд Америк 6, 15,
41, 44

П

Падма 21
Пакистан 31
Порт-О-Пренс 34

Р

Рави 7, 27, 43
Рио де Жанейро 6, 40
Рим 17
Робот 24
Руди 7, 9

С

Сан Франциско 6, 18
Санжя 7, 39
Санта Лусия 41
Саудын Араб 7, 37, 45
Сүм (христийн) 13, 36
сүмүүд 38, 39, 42
сүлжих 25
суурингууд 12-13, 15
суртчилах 25

сүм (далын шашины)
37
Сургууль 22, 32, 33
Сергей 13
Сикх 39
Софи 7, 36, 42
Стокгольм 17

Т

төрсөн өдөр 40
Төв Америк 34, 40
Тутрагын талбай 21
Тоглох 34-35
Танзани 7, 23, 44
Таогийн шашин 39
Тайлор 6, 18
Тайланд 7, 28, 45
төвд 7, 38, 42
Тора 36
тосгон 12-13, 14, 32
Турк 7, 8, 45

У

урчууд 24-25
усан хангамж 19, 33
Украин 21

Ү

үйлдвэрлэл 24-25
үйлдвэр 24-25

Х

Хятад улс 7, 24, 26, 38,
39, 41, 45
Христийн шашин 36,
40
Хотууд 16-17, 18-19
хөдөө орон нутаг 12-
13, 14, 20-21, 22-23
Хоол хүнс 20-21, 22-
23, 26-27, 28-29
Халовен 41
Хелена 7, 41
Ханукка 36

Хинду шашин 39
Холи 39
Хью 7, 22, 43
Хойд Америк 44
Хүнсний их дэлгүүр
26

Ц

Цагдаа 31
Цас 7, 14

Ш

Шинэ жил 41
шоргоолж 8
Шашин 36-39, 40
Шотланд 11
Шинто шашин 39
Шүтээн 39
Швед 7, 17, 24, 41, 45
Шүхэр 24

Э

Эдинбург 11
эмч 30, 43
Энэтхэг 7, 10, 25, 27,
39, 43
Эцэг эх 8-9

Ю

Юста 7, 25

Я

Япон 7, 16, 21, 39

Дэлхийн хүүхдүүдийн тухай

Дэлхийн хүүхдүүдийн тухай Оксфордын анхны ном нь хүүхдүүдийн тухай өгүүллэгээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт амьдрал гайхамшигтай олон янз байдаг талаар өгүүлдэг. Австралийн алс хол нутгийн хонины аж ахуйн амьдрал, Энэтхэгийн хүн, хөл хөдөлгөөн ихтэй захын ажил хөдөлмөр зэргийг оролцуулан хүүхдүүд өөрсдийнхөө амьдрал ахуй, гэр орон, гэр бүл, сургууль, тоглоом, тэмдэглэдэг баяр, шашин шүтлэг, өөрсдийнхөө ирээдүйд итгэх итгэлийнхээ талаар ярьж байна.

- ◆ Дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүүхдүүдийн хувийнхаа амьдралын талаар өгүүлсэн өгүүллэг
- ◆ Хүн, газар орны тухай гайхамшигтай гэрэл зургууд
- ◆ Хөгжилтэй, хийхэд хялбар дасгал ажлууд
- ◆ Хүний амьдран буй газар орон, амьдралынх нь талаар өргөнөөр хамруулж тусгажээ.

Рибекa Трэйс нь хүүхдэд зориулж өргөн хүрээтэй сэдвээр бичсэн билээ. Түүний нэрийг Рон-Поуленкийн нэрэмжит ШУ-ны шагналд дэвшүүлээд байгаа билээ.



Хэвлэл нийтлэлийг Интерпресс ХХК

Орчуулагч Н.Оюунбаяр
Хянагч Ж.Гэрэлмаа



Дэлхийн бөмбөйтэй хамтран хэрэгжүүлж буй
"Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.
Худагдалахыг хориглоно.